



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20~~23~~оны 4. дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар ТҮЗ2023-03/03

Улаанбаатар
хот

Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дэх хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.11, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг тус тус үндэслэн хурлаас ТОГТООХ Нь:

1. Компанийн бүхий л үйл ажиллагаанд ил тод, олон нийтэд нээлттэй, сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилгоор дараах баримт бичгүүдийг шинээр болон шинэчлэн хавсралтаар баталсугай. Үүнд:

- 1.1 “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт №1-р,
- 1.2 “Нэр дэвшүүлэх хорооны дүрэм”-ийг Хавсралт №2-р,
- 1.3 “Цалин хөлс, урамшууллын хорооны дүрэм”-ийг Хавсралт №3-р,
- 1.4 “Эрсдэл, Аудитын хорооны дүрэм”-ийг Хавсралт №4-р
- 1.5 “Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт №5-р,
- 1.6 “Дотоод хяналтын бодлого”-ыг Хавсралт №6-р,
- 1.7 “Ёс зүйн дүрэм”-ийг Хавсралт №7-р,
- 1.8 “Ногдол ашгийн журам”-ыг Хавсралт №8-р,
- 1.9 Хөндлөнгийн аудит томилох журам”-ыг Хавсралт №9-р,
- 1.10 “Комплайнсын хяналтын бодлого”-ыг Хавсралт №10-р,
- 1.11 “Ашиг сонирхлыг зохицуулах журам”-ыг Хавсралт №11-р,
- 1.12 “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг Хавсралт №12-р,
- 1.13 Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журам”-ыг Хавсралт №13-р,
- 1.14 “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт №14-р
- 1.15 “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг Хавсралт №15-р

2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТҮЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн ТҮЗ03/01 тогтоолоор батлагдсан “Аудитын хорооны дүрэм”-ийг, ТҮЗ03/02 тогтоолоор батлагдсан “Цалин урамшууллын хорооны дүрэм”-ийг, ТҮЗ03/03 тогтоолоор батлагдсан “Нэр дэвшүүлэх хорооны дүрэм”-ийг, 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ТҮЗ03/10 тогтоолоор батлагдсан “Ногдол

ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгох журам"-ийг, 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн ТУЗ2020-03/09 тогтоолоор батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан баримт бичгүүдийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Огтонбаяр, Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА: Ц. БААТАРСАЙХАН/





**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

20.23оны 4. дугаар
сарын 17.-ны өдөр

Дугаар ТУЗ-2023-03/04

Улаанбаатар
 хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.1 дэх хэсэг, тус компанийн дүрмийн дугаар зүйлийн 8.9.11-р зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Эрсдэл, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай.
- Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан хороодын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнийг дараах байдааар баталсугай.

2.1 Эрсдэл, Аудитын хорооны даргаар: В.Хүрэлхад

Гишүүдэд: Д.Байгальмаа
Ц.Оюунцэцэг

2.2. Нэр дэвшүүлэх хорооны даргаар: Д.Байгальмаа

Гишүүдэд: Д.Хулан
В.Хүрэлхад

2.3 Цалин, урамшууллын хорооны даргаар: В.Хүрэлхад

Гишүүдэд: Ц.Цэцэнхүү
Д.Байгальмаа

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь харьяалсан хороодын үйл ажиллагаанд зохих журмын дагуу оролцож компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА Ц. БААТАРСАЙХАН

